



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Ажил гүйцэтгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ази-Европын дээд түвшний 11 дэх удаагийн уулзалтын бэлтгэл ажлыг хангахтай холбогдуулан, үерийн хамгаалалтын далан сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2016 оны 06 дугаар сарын 30-нд багтаан гүйцэтгэж дуусгасугай.

2. Баруун салбарын үерийн хамгаалалтын далан сувгийн лаг цэвэрлэгээний ажлын төсвийн зардлын задаргааг 1 дүгээр хавсралтаар, Зүүн салбарын үерийн хамгаалалтын далан сувгийн лаг цэвэрлэгээний ажлын төсвийн зардлын задаргааг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Төсвийн зардлын задаргааны дагуу машин механизм, тээврийн хэрэгсэл, ажилчдын цалинг 8 909 772 /Найман сая есөн зуун есөн мянга долоон зуун далан хоёр/ төгрөгт багтаан ажиллуулахыг Баруун салбарын авто баазын Ерөнхий инженер О.Лувсандагвад, 8 077 748 /Найман сая далан долоон мянга долоон зуун дөчин найман/ төгрөгт багтаан ажиллуулахыг Зүүн салбарын авто баазын Инженер, эдийн засагч Н.Ууганбаярт, инженер техникийн ажилтан, ажилчдын цалингийн шууд зардлыг 19 616 443 /Арван есөн сая зургаан зуун арван зургаан мянга дөрвөн зуун дөчин гурван/ төгрөгт багтаан ажиллуулахыг Баруун салбарын 3 дугаар хэсгийн инженер Д.Ариунбаатарт, 16 419 990 /Арван зургаан сая дөрвөн зуун арван есөн мянга есөн зуун ерэн/ төгрөгт багтаан ажиллуулахыг Зүүн салбарын 5 дугаар хэсгийн инженер С.Батсайханд нарт тус тус даалгасугай.

4. Дээрх төсвийн задаргааны дагуу тооцоог хийж, бүртгэл хөтлөхийг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /Б.Мөнх-Оргил/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ГАНЗОРИГ



ТТ38526 ±8115125

2130300111